

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 6 дүүгэр
сарын 25-ны өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Үнэт цаасны зах зээл дээр ажиллах мэргэжилтний
ажил үйлчилгээ явуулах эрхийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 219 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах тухай журам”-ын 6.1.2 болон “БиДиСек” ХК-ийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн Ажлын хэсгийн дүгнэлт, саналыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “БиДиСек” ХК-ийн Гүйцэтгэх захирал Данзангийн Даянбилгүүн, Дэд захирал Бүрэнмэндийн Лхагвадорж нарын үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхийг тус тус түдгэлзүүлсүгэй.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН